

Монгол Улсын Улаанбаатар хотын хатуу хог хаягдлын менежментийн чадавхийг бэхжүүлэх техник хамтын ажиллагааны төсөл

Агуулга

1. Олон нийтийн санал асуулга судалгаа
2. Нэмэлт сэдэв
3. Ойрын үед хэрэгжүүлэх ажил, арга хэмжээ
4. Шинэ вэб хуудас

1. Олон нийтийн санал асуулга

Манай төсөл 2009 оны 10 дугаар сараас хэрэгжиж эхлээд гурван сар болж байна. Өнгөрсөн хугацаанд төсөл хэрэгжүүлэгч Монголын талын байгууллага болох Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны ОБХХМХ, ХТГ, дүүргийн ЗДТГ ба бусад байгууллагуудтай хамтран төрөл бүрийн ажлуудыг хийгээд байна. Энэхүү Мэдээллийн тоймын 2 дахь дугаараар тэдгээр ажлуудын нэг болох олон нийтийн санал асуулга авсан тухай судалгааны дүнг танилцуулах болно.

Судалгааны зорилго

Олон нийтийн санал асуулгыг авсан зорилго нь УБ хотын хүрээлэн буй орчин ба эрүүл ахуйн нөхцөл байдал, хатуу хог хаягдлын менежментийн үйлчилгээний талаарх иргэдийн сэтгэл ханамжийн түвшинг тодорхойлоход оршино. Судалгааг төсөл хэрэгжүүлэх шатны эхэнд, дунд ба эцэст гэж 3 удаа хийхээр төлөвлөөд байгаа бөгөөд судалгааны дүнг төслийн зорилгод амжилттай хүрсэн эсэхийг дүгнэх шалгуур үзүүлэлт болгож ашиглана.

Судалгааны тухай

- Судалгааны аргачлал: Санал асуулгын хуудсыг тарааж, бөглөсөн хуудсыг цуглуулах
- Хамрагдах хүрээ: УБ хотын 6 дүүрэг бүрээс гэр хорооллын 2, орон сууцны хорооллын 2 хороодыг тус тус сонгож нийт 24 хороог судалгаанд хамруулав.
- Хамрагдах оршин суугчид: УБ хотын төвийн 6 дүүргийн¹ өрхүүд.
- Хамрагдах өрхийн тоо: (1) гэр хорооллын 420 өрх (6 дүүрэг х 2 хороо х 35 = 420), (2) орон сууцны хорооллын 420 өрх
- Асуултын тоо: 13
- Агуулга: (1) Судалгаанд хамрагдсан иргэдийн тухай мэдээлэл, (2) УБ хотын хүрээлэн буй орчин ба эрүүл ахуйн нөхцөл байдал, (3) УБ хотын ХХМ-д тулгамдаж буй асуудлууд

Судалгааны дүн

(1) Судалгаанд хамрагдсан иргэдийн тухай мэдээлэл

Судалгаанд хамрагдсан иргэдийн насны ба хүйсийн эзлэх хувийг доорх хүснэгтээр үзүүлэв. Нийт иргэдийн 39,3% эрэгтэй, 58,6% эмэгтэй байв.

Түүнчлэн, судалгаанд хамрагдсан иргэдийн 44,1% нь 48 ба түүнээс дээш настай байсан ба бусад нь 48 ба түүнээс доош насны бүлгүүдэд жигд хувиарлагдсан байв.

Нас	Эр	Эм	(Хоосон)	Нийт
18-23	1,5%	2,5%	0,0%	4,0%
24-29	4,5%	6,5%	0,0%	11,0%
30-35	4,6%	8,0%	0,0%	12,6%
36-41	5,3%	8,0%	0,1%	13,4%
42-47	5,0%	8,2%	0,0%	13,2%
48 дээш	18,5%	25,2%	0,4%	44,1%
(Хоосон)	0,0%	0,1%	1,6%	1,7%
Нийт	39,3%	58,6%	2,1%	100,0%

Судалгаанд хамрагдсан иргэдийн боловсролын түвшинг доорх хүснэгтээр үзүүлэв. Нийт иргэдийн 40 гаруй хувь дээд боловсролтой байсан бөгөөд тэдгээрийн 70 гаруй хувь орон сууцны хороололд амьдарч байна.

Боловсролын түвшин	Орон сууц	Гэр хороо	Нийт
Дээд	31,0%	12,6%	43,6%
Тусгай дунд	8,5%	13,3%	21,8%
Бүрэн дунд	7,7%	16,7%	24,5%
Бүрэн бус дунд	1,9%	5,1%	7,0%
Бага буюу боловсролгүй	0,2%	1,0%	1,2%
(Хоосон)	0,4%	1,6%	1,9%
Нийт	49,8%	50,2%	100,0%

(2) УБ хотын хүрээлэн буй орчин ба эрүүл ахуйн нөхцөл байдал


A1-1: УБ хотын хүрээлэн буй орчин ба эрүүл ахуйн нөхцөл байдалд Та сэтгэл ханамжтай байна уу?

Энэхүү асуултын хариултын дүнг оршин суух бүсээр нэгтгэж дүн шинжилгээ хийв. УБ хотын хүрээлэн буй орчин ба эрүүл ахуйн нөхцөл байдлын талаар дунд ба түүнээс дээш гэж хариулсан дүнг нэгтгэхэд орон сууцны хороололд 43,6%, гэр хороололд 40,8% ба дунджаар 42,1%-тай байна. Сэтгэл ханамжийн түвшин орон сууцны хороололд бага зэрэг өндөр байгаа боловч их хэмжээний ялгаа ажиглагдахгүй байна. Өөрөөр хэлбэл, энэхүү асуултын хувьд УБ хотын иргэдийн санал ба байр суурь нь оршин суух бүсээс хамаарахгүйгээр, ерөнхийдөө нийтлэг нэг байна гэж хэлж болох юм.

A1-1 дүгээр асуултын хариултын дунд ба түүнээс дээш гэж хариулсан орон сууцны хорооллын оршин суугчдын дүнг нэгтгэхэд тус тус БГД31,5%, БЗД57,9%, ЧД39,1%, ХУД41,4%, СБД60,2% ба СХД32,9%-тай байна. Хамгийн өндөр үзүүлэлт СБД60,2%-тай байхад БЗД57,9%-тай удаалж байна. Хамгийн бага үзүүлэлтээр БГД31,5%-тай байхад

¹ Сүхбаатар (СБД), Чингэлтэй (ЧД), Сонгинохайрхан (СХД), Баянзүрх (БЗД), Баянгол (БГД), Хан-Уул (ХУД)

СХД32,9%-тай түүний өмнө нь байна.



Дунд ба түүнээс дээш гэж хариулсан гэр хорооллын оршин суугчдын дүнг нэгтгэхэд БГД31,8%, БЗД41,4%, ЧД44,0%, ХУД50,1%, СБД40,8% ба СХД36,2% тус тус байна. Хамгийн өндөр үзүүлэлтээр ХУД50,1%-тай байхад ЧД44,0%-тай удаалж байна. Хамгийн бага үзүүлэлтээр БГД31,8%-тай байхад СХД36,2%-тай түүний өмнө нь байна.

БГД ба СХД-ийн орон сууц ба гэр хорооллын иргэдийн сэтгэл ханамжийн түвшин хамгийн бага байв.

A1-2: Одоогоор УБ хотын хэмжээнд тулгамдаж буй хамгийн хүндрэлтэй асуудал юу вэ?

Судалгаанд хамрагдсан орон сууц ба гэр хорооллын оршин суугчдын 80 орчим хувь нь УБ хотын хүрээлэн буй орчин ба эрүүл ахуйн нөхцөл байдлын хамгийн тулгамдаж буй асуудлаар “агаарын бохирдол” гэж хариулт өгсөн байна. Бусад асуудлуудтай харьцуулахад маш их ялгаатай, өндөр тоо гарсан боловч “хог хаягдлын асуудлыг” судалгаанд оролцсон хүмүүсийн 3,4% хариулсан буюу УБ хотод тулгамдаж буй асуудлуудын хоёрдугаарт орсон байна.

(3) УБ хотын ХХМ-ийн асуудал


A2-1: УБ хотын ХХМ-ийн үйлчилгээ (хаях, цуглуулах, тээвэрлэх, дарж булах)-д Та сэтгэл ханамжтай байна уу?

A2-1 дүгээр асуултын хариултын дүнг нэгтгэж оршин суух бүсээр нь дүн шинжилгээ хийв. Дунд ба түүнээс дээш гэж хариулсан хариултыг нэгтгэхэд орон сууцны хороололд 53,8%, гэр хороололд 58,1% ба дунджаар 55,9% байна. А1-1 дүгээр асуултын УБ хотын хүрээлэн буй орчин ба эрүүл ахуйн нөхцөл байдалд сэтгэл ханамжтай байгаа түвшинтэй харьцуулахад хатуу хог хаягдлын менежментийн үйлчилгээнд сэтгэл ханамжтай байгаа түвшин өндөр байгаа нь харагдаж байна.

A2-1 дүгээр асуултын хариултын дунд ба түүнээс дээш гэж хариулсан зөвхөн орон сууцны хорооллын оршин суугчдын дүнг нэгтгэхэд БГД35,8%, БЗД62,3%, ЧД59,4%, ХУД48,6%, СБД68,3% ба СХД50,0%-тай тус тус байна. Хамгийн өндөр үзүүлэлтээр СБД68,3%-тай байхад БЗД62,3%-тай удаалж байна. Хамгийн бага үзүүлэлтээр БГД35,8%-тай байхад СХД48,6%-тай түүний өмнө нь байна.

Дунд зэрэг ба түүнээс дээш гэж хариулсан гэр хорооллын оршин суугчдын дүнг нэгтгэхэд БГД49,2%, БЗД65,7%, ЧД63,6%, ХУД67,2%, СБД45% ба СХД58% тус тус байна. Хамгийн өндөр үзүүлэлтээр ХУД67,2%-тай байхад БЗД65,7%-тай удаалж байна. Хамгийн бага үзүүлэлтээр СБД45%-тай байхад БГД49,2%-тай түүний өмнө нь байна.

Зургаан дүүргээс СБД-ийн орон сууцны хорооллын оршин суугчдын сэтгэл ханамжийн түвшин хамгийн өндөр гарсан боловч гэр хорооллын оршин суугчдын сэтгэл ханамжийн түвшин хамгийн бага гарсан байна. БЗД-ийн орон сууц ба гэр хорооллын оршин суугчдын сэтгэл ханамжийн түвшин өндөр байсан бол БГД-ийн иргэдийн сэтгэл ханамжийн түвшин орон сууц болон гэр хороолол гэж ялгалгүй доогуур гарсан байна.



A2-2: Одоогийн байдлаар УБ хотын ХХМ-ийн хамгийн хүндрэлтэй асуудал юу вэ?

УБ хотын ХХМ-ийн хамгийн хүндрэлтэй асуудал нь “Иргэдийн хогоо хаядаг байдал, ухамсар нь тааруухан буюу хангалтгүй” гэсэн хариулт байв. Энэ хариултыг судалгаанд хамрагдсан орон сууцны хороололд оршин суух иргэдийн 36,3%, гэр хорооллын иргэдийн 35,9% ба дунджаар 36,1% нь сонгож хариулжээ. Дараагийн тулгамдаж буй асуудлаар “Хог хаягдлыг ангилан ялгаж, дахин боловсруулах жижиг, дунд үйлдвэр байхгүй” гэсэн хариултыг судалгаанд хамрагдагсадын орон сууцны хорооллын 19,5%, гэр хорооллын 14,1% ба дунджаар 16,8% нь сонгож хариулсан нь иргэд хогоо ангилах, дахин ашиглах чиглэлээр идэвхтэй үйл ажиллагаа явуулах эрмэлзэлтэй боловч хогийг боловсруулах үйлдвэр, байгууламж байхгүй байгаа өнөөгийн байдлыг илэрхийлж байна. Нөгөөтэйгүүр, орон сууцны хорооллын оршин суугчдаас гэр хорооллын иргэд арай өөр асуудалтай тулгарч байгаа бөгөөд тэрээр “Хог хаягдал цуглуулах үйлчилгээ нь хангалтгүй” гэж хариулжээ.

A2-4: Таны амьдардаг нутаг дэвсгэрт хог хаягдал цуглуулах үйлчилгээнд Та сэтгэл ханамжтай байна уу?

ХТГ-ын үйлчилгээ үзүүлдэг орон сууцны хороололд дунд ба түүнээс дээш гэж хариулсан иргэдийн сэтгэл ханамжийн түвшин хамгийн өндөр буюу 85,4%-тай байхад ТҮК-ээс бусад хувийн компанийн үйлчилгээг авдаг иргэдийн сэтгэл ханамжийн түвшин хамгийн бага буюу 42,9%-тай байна. Гэр хороололд ТҮК-ийн үйлчилгээг авдаг иргэдийн сэтгэл ханамжийн түвшин хамгийн өндөр буюу 72,5%-тай байхад хорооны ЗД-ын хог тээвэрлэх үйлчилгээг авдаг иргэдийн сэтгэл ханамжийн түвшин хамгийн бага буюу 53,5%-тай байна.

Нийтдээ, дунд ба түүнээс дээш гэж хариулсан ХТГ-ын үйлчилгээ үзүүлдэг бүсийн оршин суугчдын хариултуудыг нэгтгэхэд сэтгэл ханамжийн түвшин хамгийн өндөр буюу 77,0%-тай байхад нэг, хоёр хороонд үйлчилгээ үзүүлдэг хувийн тээвэрлэгч байгууллагыг хасч тооцоо судалгаа хийхэд ТҮК-ийн үйлчилгээг авдаг иргэдийн сэтгэл ханамжийн түвшин хамгийн бага буюу 66,7%-тай байна.

Тээвэрлэгч байгууллага	Орон сууц	Гэр хороолол	Нийт
Дүүргийн ЗДТГ-ын дэргэдэх байгууллага	82,1%	65,7%	72,1%
Хороо ЗД	-	53,5%	53,5%
ХТГ	85,4%	68,6%	77,0%
ТҮК	62,5%	72,5%	66,7%
ТҮК-ээс бусад хувийн компани	42,9%	-	42,9%

- Судалгаанд хамрагдсан бүсэд үйлчилгээ үзүүлдэггүй

A2-5: Хог хаягдал цуглуулах үйлчилгээ нь яагаад хангалтгүй байна гэж Та үзэж байна вэ?

Хог хаягдал цуглуулах үйлчилгээний хамгийн хүндрэлтэй асуудал нь “1.Хог хаягдал цуглуулах хэлбэр нь хангалтгүй” гэсэн хариултыг судалгаанд хамрагдсан ихэнх иргэд сонгож хариулсан буюу орон сууцны хорооллын 25,6%, гэр хорооллын 19,8% ба дунджаар 22,6%-тай хариулсан байна. Энэхүү дүнг үзэхэд А2-4 дүгээр хариултын дагуу ХТГ-ын үйлчилгээ үзүүлдэг нутаг дэвсгэрт оршин суудаг иргэдийн сэтгэл ханамжийн түвшин хамгийн өндөр байгаа байдал нь, нөгөөтэйгүүр, ХТГ-ын ажилчдын хог хаягдлаа цуглуулдаг хэлбэр нь иргэдэд хамгийн их тааламжтай буюу хангалттай байна гэж дүгнэж болох байна. Дараагийн хүндрэлтэй асуудлаар “6.Зарим иргэд хогны төлбөрөө төлдөггүй” гэсэн хариултыг нийт судалгаанд хамрагдсан иргэдийн 21,5% буюу орон сууцны хорооллын 15,9%, гэр хорооллын 26,9% тус тус сонгож хариулжээ. Энэхүү үзүүлэлт гэр хороололд харьцангуй өндөр гарсан байна. Гурав дахь хүндрэлтэй асуудлаар “3.Хог хаягдал цуглуулах хуваарь байхгүй” гэж нийт судалгаанд хамрагдсан иргэдийн 21,3% буюу орон сууцны хорооллын 19,7%, гэр хорооллын 22,9% тус тус сонгож хариулжээ.

A2-7: Нийслэлийн засаг захиргааны зүгээс Таны амьдарч буй нутаг дэвсгэрт хогийг өрхийн хэмжээнд ялгуулж улмаар ангилан цуглуулдаг тогтолцоог нэвтрүүлэх төлөвлөгөөтэй байна. Иймд, Та гэртээ үүсч буй хогоо “дахин ашиглах боломжтой” болон “дахин ашиглах боломжгүй” гэсэн байдлаар хогоо ялахаг үйл ажиллагаанд хамтран ажиллах хүсэлтэй байна уу?

Судалгаанд хамрагдсан орон сууцны хороололд амьдардаг иргэдийн 88,8%, гэр хороололд – 82,7% ба дунджаар 85,7%-тай гарсан нь нэлээд өндөр үзүүлэлт болно.

Судалгааны ололтууд

(1) УБ хотын хүрээлэн буй орчин ба эрүүл ахуйн нөхцөл байдлын талаар

- УБ хотын хүрээлэн буй орчин ба эрүүл ахуйн нөхцөл байдлын талаарх орон сууц болон гэр хороололд оршин суух иргэдийн сэтгэл ханамжийн түвшин нь хатуу хог хаягдлын менежментийн талаарх сэтгэл ханамжийн түвшинтэй харьцуулахад доогуур байгаа нь иргэдэд агаарын бохирдлын асуудал УБ хотын хамгийн тулгамдсан асуудал гэж үзсэнтэй холбоотой болно.
- Нөгөөтэйгүүр, энэхүү судалгааг 11 дүгээр сард авсан тул цаг агаар хүйтэрч өвлийн улирал


эхэлсэнтэй холбогдуулан гэр хорооллын иргэд нүүрс түлж, УБ хотын төвийн хэсэг тэр чигээрээ нүүрсний утаанд автаж байсан тул иргэдийн сэтгэл санааг зовоож байсан, нийгмийн шийдвэрлэх шаардлагатай гэсэн томоохон асуудал нь агаарын бохирдол болж улмаар энэхүү судалгааны дүнд ч тодорхой хэмжээгээр нөлөөлсөн гэж үзэж байна.

(2) УБ хотын хатуу хог хаягдлын менежментийн байдлын талаар

- УБ хотын хатуу хог хаягдлын менежментийн талаарх иргэдийн сэтгэл ханамжийн түвшинг хүрээлэн буй орчин ба эрүүл ахуйн нөхцөл байдлын талаарх сэтгэл ханамжийн түвшинтэй харьцуулахад 10%-иар илүү байгаа нь оршин суугчид хатуу хог хаягдлын асуудлыг хүрээлэн буй орчны асуудалтай харьцуулахад тийм их ноцтой асуудал гэж үзэхгүй байна. Дүүрэг дүүргээр иргэдийн хатуу хог хаягдлын менежментийн талаарх сэтгэл ханамжийн түвшинд дүн шинжилгээ хийхэд БЗД хамгийн өндөр байхад БГД хамгийн бага үзүүлэлттэй байна. Түүнчлэн, СБД-ийн орон сууцны хороолол бусад дүүргийн орон сууцны хороололтой харьцуулахад хамгийн өндөр үзүүлэлттэй байхад тус дүүргийн гэр хороолол хамгийн байга үзүүлэлттэй байна. БГД хатуу хог хаягдлын менежментийн талаар ч хүрээлэн буй орчин ба ахуйн нөхцөл байдлын талаар ч хамгийн бага үзүүлэлттэй байна.
- УБ хотын хатуу хог хаягдлын менежментийн үйлчилгээнд тулгамдаж байгаа хамгийн хүндрэлтэй асуудлаар “Иргэдийн хогоо хаядаг байдал нь тааруухан буюу хангалтгүй” гэсэн асуудлыг орон сууц ба гэр хорооллын иргэд сонгон хариулжээ. Нөгөөтэйгүүр, хог хаягдал цуглуулах үйлчилгээний талаарх иргэдийн сэтгэл ханамжийн түвшин харьцангуй өндөр гарсан боловч тэрхүү үйлчилгээний хамгийн хүндрэлтэй асуудал юу вэ гэж асуухад “Хог хаягдал цуглуулах байдал, хэлбэр нь хангалтгүй” гэж хариулсан нь ерөнхийдөө иргэдийн хогоо хаядаг, түүнийг ачдаг байдал нь асуудалтай байна гэдгийг харуулж байна.
- УБ хотын хэмжээнд хог хаягдал ангилах, дахин ашиглаж боловсруулах үйл ажиллагааг нэвтрүүлэх тохиолдолд нийт судалгаанд хамрагдсан иргэдийн 85% нь хамтран ажиллах хүсэлтэй байна гэдгээ илэрхийлсэн нь УБ хотын иргэд хүрээлэн буй орчин ба хатуу хог хаягдлын менежментийн талаар харьцангуй өндөр мэдлэг, ухамсартай байна.

2. Нэмэлт сэдэв: Хог гэж юу вэ?

Өмнөх дугаарт дурьдсан хотын хатуу хог хаягдлын урсгал сэдвийн үргэлжлэл болгон энэ дугаараар УБ хотод хог хаягдлыг анхан шатны эх үүсвэр дээр хэрхэн хаядаг тухай (3-р зүйл) тайлбарлах болно.



Хотын хатуу хог хаягдлын урсгал

3. Хаях

УБ хот нь орон сууц ба гэр хороолол гэж хот байгуулалтын хувьд хоёр хэсэгт хуваагдах бөгөөд орон сууцны хороолол нь халуун ус, дулаан зэрэг дэд бүтцийн шугам сүлжээтэй байхад гэр хороололд тийм дэд бүтэц байхгүй байдаг. Орон сууцны хорооллыг 50-60-д оны үед баригдсан 4-5 давхар барилгууд, 70-80-д оны үед баригдсан 5-9 давхартай өндөр барилгууд ба сүүлийн үед баригдсан орон сууц гэж гурван төрөлд хувааж болно. Тэдгээр барилга, орон сууцны төрлүүд нь өөр өөрийн хог хаях тогтолцоотой болно.

1. 50-60-д оны үеийн барилгууд:

Байрны орчны жижүүр нь тухайн байрны оршин суугчдын гялгар уутанд хийж хаясан хогийг хадгалж байгаад хогны машин дуут хөгжим дуугаргаж ирэхэд хогны машинд гаргаж өгдөг байна. Энэхүү тогтолцоогоор хогийг эх үүсвэр дээр нь ангилан цуглуулах тогтолцоог нэвтрүүлэхэд хамгийн тохиромжтой байх болно.



2. 70-80-д оны үеийн барилгууд:

Тэдгээр барилгуудын ихэнх нь хогны бункертэй бөгөөд оршин суугчид нь дуртай цагтаа хогоо гаргаж хаядаг байна. Бункер нь хог хадгалах зориулалттай тул энэхүү тогтолцоо нь иргэд, оршин суугч нарт нэн тохиромжтой тогтолцоо боловч бункерт байгаа хогийг өдөр тутам ачихгүй тохиолдолд эрүүл ахуйн асуудал үүсэхийн зэрэгцээ анхан шатны эх үүсвэр дээр ангилан цуглуулах тогтолцоог нэвтрүүлэхэд нэлээд хүндрэлтэй байх болно.



3. Сүүлийн үеийн барилгууд

Сүүлийн үеийн барилгууд нь ихэвчлэн хог түр хадгалах цэгтэй байх бөгөөд тэнд нь оршин суугчид хогоо гарган хаяж хогны машин



үе үе ирж ачдаг байна. Энэ тохиолдолд хогийг ангилан хаях тогтолцоог нэвтрүүлэхийн тулд хогийг тус тусад нь хаях тусгай хогийн сав бэлтгэх шаардлагатай бөгөөд хот дотор хог түүдэг хүмүүс хаягдал түүхий эд цуглуулж байх явцдаа хогийг гудамжаар замбараагүй тарааж хаях асуудал үүсдэг. Нөгөөтэйгүүр, гэр хороололд хогны машин хашааны хаалга бүрээс очиж хогийг нь ачдаг бөгөөд оршин суугчид хогны машин ирэхэд төмөр торхонд хадгалж байгаа хогоо хогны машинд ачдаг байна. Энэхүү тогтолцоогоор анхан шатны эх үүсвэр дээр ангилан цуглуулах тогтолцоо нэвтрүүлэх нь тохиромжтой байх боловч үүсдэг хог нь ихэвчлэн үнс байдаг тул дахин ашиглах боломжтой хогны хэмжээ маш бага гардаг байна.



3. Ойрын үед хийх ажил, арга хэмжээ

- **3R семинар** (Хог гарах хэмжээг багасгах, нэгэнт үүссэн хогийг дахин ашиглах, дахин боловсруулах): 4 дүгээр сар
- **WEEE судалгаа** (гэр ахуйн цахилгаан, электрон барааны хог хаягдал): Хэрэгжүүлэх явцад
- **Туршилтын төсөл:** Төлөвлөлтийн явцад

4. Манай шинэ вэб хуудас

Манай төслийн вэб хуудас шинэчлэгдсэн боловч одоогоор зөвхөн англи хэл дээр байгаа тул ойрын үед монгол хэл дээрх хуудсыг бэлэн болгоно. Вэб хуудасны хаягийг доор үзүүлэв. Манай төслийн холбогдолтой тайлан мэдээ болон семинар, хурлын тухай мэдээллийг цаг тухайд нь уншигч Та бүгдэд хүргэх зорилгоор интернет дээрх вэб хуудсыг байнга шинэчилж байх болно. Манай вэб хуудастай уншигч Танд танилцах боломж олдоно гэдэгт бид найдаж байна.

Монгол Улсын Улаанбаатар хотын хатуу хог хаягдлын менежментийн чадавхийг бэхжүүлэх техникийн хамтын ажиллагааны төслийн ЖАЙКА-ийн зөвлөх баг

[Ажлын байрны хаяг]

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 6 дугаар хороо, Г.Бумцэнд-68, Хот тохижилтын газрын байр

Утас: 327128, Факс: 323128

Вэб хуудас: <http://www.kkcub.mn/>